

2024 оны 05 сарын 22-өдөр

Дугаар 42

Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэг, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, “Худалдаа, хөгжлийн банк” ХК (цаашид “Банк” гэх)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.11.20 дахь заалтыг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ нь:**


1. Банкны холбогдох этгээд болох Ти Ди Би Капитал ХХК-тай байгуулсан 2021 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн “Хувьцаа худалдах, худалдан авах, хувьцаагаар гэрчлэгдсэн шаардах эрх шилжүүлэх гэрээ”, 2021 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн “Авлага, өглөг үүсгэх гэрээ”-г тус тус дүгнэж, Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулсан нөхцөлийн дагуу сонирхлын зөрчилтэй хэлцэл хийж, акт үйлдэхийг зөвшөөрсүгэй.

2. Банкны холбогдох этгээд болох Си Эн Би Консалтинг ХХК-тай байгуулсан 2021 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн “Хувьцаа худалдах, худалдан авах гэрээ”, 2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн “Хувьцаа худалдах, худалдан авах гэрээ”, 2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн “Барьцаат авлагын гэрээ”-г тус тус дүгнэж, Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулсан нөхцөлийн дагуу сонирхлын зөрчилтэй хэлцэл хийж, акт үйлдэхийг зөвшөөрсүгэй.

3. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотой гэрээ, хэлцэл болон холбогдох бусад баримт бичигт Банкныг төлөөлөн гарын үсэг зурах, холбогдох этгээдэд дамжуулан итгэмжлэл олгох болон шаардлагатай бусад арга хэмжээ авч ажиллах эрхийг Гүйцэтгэх захирал (О.Орхон)-д олгосугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Ажлын алба (Н.Нямсүрэн)-нд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



РАНДОЛФ КОППА